



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 15-өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн б дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цемент шохой” ХК-ийн ерийг хувьцаагаар солих зорилготой нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,751,388,203 /хоёр тэрбум долоон зуун тавин нэгэн сая гурван зуун наян найман мянга хоёр зуун гурав/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэнтэй холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандaa чанд мөрдөж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Цемент шохой” ХК /А.Шоовдор/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд болон Оюуны өмч, улсын бүртгэлийн срөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН